

Нийслэлийн архивын газар



ХҮНС ХАНГАМЖ ТӨВ  
ОНӨААТТУГ

Хөмрөг №  
Данс №  
ХН№

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд  
хийсэн аудитын дүгнэлт

Эхэлсэн: 2016  
Дууссан: 2016  
Хуудасны тоо: 20  
Хадгалах хугацааны  
жагсаалтын зүйлийн дугаар: ҮЖ-42  
Хадгалах хугацаа: Байнга

Дотоод товьёг

| д/д | Баримтын индекс | Баримын огноо | Баримтын тэргүү                                            | Баримтын хуудасны дугаар | Тайлбар |
|-----|-----------------|---------------|------------------------------------------------------------|--------------------------|---------|
| 1   | 01              | 2016          | 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт | 1-20                     |         |

Дүн тоо: .. 20 .. /хорь / хуудас баримт бичиг бүртгэв.

Дотоод товьёгны хуудасны тоо.....1..... / нэг / хуудас.

Дотоод товьёг үйлдсэн:

Хүний нөөц, бичиг  
хэргийн ажилтан

П.Хандсүрэн

2019.09.15



СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК

**“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын 2016 оны 12-р сарын 31-нээр дуусвар  
болсон санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудит**



## “ХҮНС ХАНГАМЖ ТӨВ” ОНӨААТҮГ- ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:

С.Энхбаатар  
Нийслэлийн аудитын  
газрын дэд дарга:  
Утас:327734

А.Цогбаяр  
Санхүүгийн аудитын  
III шалбаны менежер:  
Утас:315558

ТАБ-ын хаяг:  
Сүхбаатар дүүрэг, 8-й  
хороо, Лхагвасүрэнгийн  
гудамж  
Цахим хуудас: city.audit.mn

“Стандарт дүгнэлт аудит  
ХХК

Захирал В.Даваасүрэн  
Утас:70111721

Цахим хаяг:

Аудит.оф.ул.Тонгалд

Аудиторын туслах: Д.Майцэцэг

НАГ-2017/23/СТА-ОНӨААН

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтын дагуу Нийслэлийн аудитын газрын захиалгаар “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд НАГ-2017/23/СТА-ОНӨААН “Стандарт дүгнэлт Аудит” ХХК аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийлээ.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт/СТОУС/ түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Тус газар санхүүгийн тайлангаа СТОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Уг газрын санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газар болон Стандарт дүгнэлт аудит ХХК-ийнүүрэг юм.

Уг газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 9 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дүгээр сарын 27-ийг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн “Стандарт дүгнэлт аудит” ХХК-ийн аудитор В.Даваасүрэн, аудиторын туслах Д.Майцэцэг нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Тус газар 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 24-ны 73 дугаар албан бичгийн дагуу “Стандарт дүгнэлт аудит” ХХК-д ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасан хугацаанаас 8 хоногоор хоцроосон байна.

“Стандарт дүгнэлт аудит” ХХК аудитыг 2017 оны 3 дугаар сарын 15-нд “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын удирдлагад гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ нь Хөдөлмөрийн, Төсвийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах, Нягтлан бодох бүртгэлийн, ААНОАТ-ын, НӨАТ-ын, Нийгмийн даатгалын, ХХОАТ-ын, Шилэн дансны тухай хуулиуд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн

гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн Сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**

Тус газрын дүрмийн 4.1 *“Нийслэлийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг эрүүл ахуй стандарт шаардлага хангасан баталгаатай чанартай хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангана”* гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. *“Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана.”* гэж заасны дагуу “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын захирал төсвийг захиран зарцуулж байна.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт, хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 4-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг болон нягтлан бодох бүртгэлийн програм нь НББОУС, СТОУС-тай нийцсэн байна.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн

мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

"Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн "Мэжик чойс" програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

#### **Дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

"Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн зарим үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хэвийн байна.

#### **Байгууллагын орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

Тус төв нь нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 45 сургууль, цэцэрлэг, 2 эмнэлэгт гол нэрийн хүнсний болон импортын бараа бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан, хадгалалт хамгаалалт, тээвэрлэлтийн горим хангасан бүтээгдэхүүнүүдээр хангах ажлыг зохион байгуулж, орлогоороо үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг.

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2016 оны зорилтод түвшинг Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргатай контракт гэрээгээр баталгаажуулжээ.

"Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ нь 2016 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөнд борлуулалтын орлого 3,982,190.2 мянган төгрөгөөр батлагдсан. Гүйцэтгэлээр 4,102,120.4 мянган төгрөгийн орлого орж, төлөвлөгөөг 119,930.2 мянган төгрөг буюу 3.0 хувиар давуулан биелүүлжээ.

2016 оны зорилтод түвшингийн төлөвлөгөөнд борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон удирдлагын зардлыг 3,965,380.9 мянган төгрөг байхаар батлагдсан. Гүйцэтгэлээр нийт зардалд 4,096,655.6 мянган төгрөгийг зарцуулж, 3,828.1 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

#### **Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд 2016 оны орлого, зардлыг төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, цалингийн зардлаас бусад

таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан эсэхэд 2016 оны 4, 10 дугаар саруудад нийцлийн аудит хийгдсэн болно.

#### **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу 5 дансанд эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 6 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, ХХОАТ-ыг дутуу суутгасан, НБББББ-г өөрчлөлт хийгээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь хөрөнгийн зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт сулрах, санхүүгийн тайланд буруу илэрхийлэгдэх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

#### **Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

"Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний нийт 2,666,378.3 мянган төгрөгийн /мөнгөн хөрөнгө, цалин хөлс, тээвэр шатахуун, хангамжийн материал, татвар зэрэг дансанд/ ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 65 хувь, нийт зардлын 64.0 хувь, нийт хөрөнгийн 11 хувийг тус тус эзэлж байна.

#### **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудалуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний нийт 875.0 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Харилцагчдад кассаар дамжуулан их хэмжээний бэлэн мөнгө гаргаж өгдөг, тайлант хугацааны эцэст их хэмжээний бэлэн мөнгөний үлдэгдэлтэй гарсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

2. Хүнсний бүтээгдэхүүний захиалгын програм хангамж хийлгэх гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрт 875.0 мянган төгрөг төлсөн боловч програмаа хийлгээгүй, үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

**Материаллаг бус дараахь зөрчил илэрсэн байна. Үүнд:**

1. НБББББ нь шинээр мөрдөж байгаа стандарт болон хууль эрхийн зарим актын өөрчлөлтийг тусгаагүй байна. Үүнд: Үндсэн хөрөнгөнд байгуулах элэгдэлийн хувь хэмжээг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн тогтоох, бараа материалыг зарлага болгох бодлого, аргачлал, цэвэр хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэх бодлого зэргийг холбогдох стандартад нийцүүлэн шинэчлээгүй. НБББББ-ийг өөрийн байгууллагын онцлог, эрх зүйн орчинтой нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноор ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд стандартын дагуу үнэн зөв тусгах, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, зарлагыг батлагдсан хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу зөв ангилж бүртгэх, тайлагнах, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг хангаж ажиллах зэрэг үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, стандартын хүрээнд явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

#### **Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Хууль, журам, заавар мөрдөөгүйгээс шалтгаалан гарсан 875.0 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

#### **Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

"Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудит хийх явцад анхаарал татахуйц чухал асуудал гараагүй байна

#### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй, дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал гараагүй болно.

#### **Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 875.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

"Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Стандарт дүгнэлт аудит" ХХК аудит хийж 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **Зөрчилгүй санал дүгнэлт**

"Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

#### ХЯНАСАН:

Дэд дарга:




С.Энхбаатар

Аудитын менежер:



А.Цогбаяр


Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн  
захирал



В.Даваасүрэн

#### БЭЛТГЭСЭН:

Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн  
аудитор



Д.Майцэцэг



## "ХҮНС ХАНГАМЖ ТӨВ" ОНӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Менежментийн захидал

#### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:

С.Энхбаатар  
Нийслэлийн аудитын  
газрын дэд дарга:  
Утас:327734

А.Цогбаяр  
Санхүүгийн аудитын  
Шалбаны менежер:  
Утас:315558

ТАБ-ын хаяг:  
Сүхбаатар дүүрэг, 8-  
хороо, Лхагвасүрэнгийн  
гудамж

#### Асуудал 1:

#### Мөнгөн хөрөнгө

#### Асуудал 2:

#### Авлага

#### Асуудал 3:

#### Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

## Менежментийн захидал

"Стандарт дүгнэлт аудит" ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг "Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан "Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Мөнгөн хөрөнгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**“Стандарт дүгнэлт аудит” ХХК-ийн ажиглалт**

**“Стандарт дүгнэлт аудит” ХХК-ийн зөвлөмж**

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ 2016 онд зарим харилцагчид кассаар дамжуулан их хэмжээний бэлэн мөнгө гаргаж өгдөг, тайлант хугацааны эцэст их хэмжээний бэлэн мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн байна. Тухайлбал: хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээт газруудад 192.3 сая төгрөг, оффис агуулахын барилгын зураг хийлгэхэд 16.0 сая төгрөг касснаас бэлэн мөнгөөр олгосон байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журамд тусгасан мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж, бэлэн мөнгөөр хийх гүйлгээнд тавих хяналтыг сайжруулах, бэлэн мөнгөний үлдэгдлийг тогтоосон хэмжээнээс их хэмжээгээр үлдэгдлээр хадгалах явдлыг таслан зогсоох.

**Эрсдэлүүд**

**Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг зөрчсөн байх

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг засаж, өгсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

**Үнэн зөв байдал** -Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх батламж мэдэгдэл зөрчигдөх

|                           |                           |
|---------------------------|---------------------------|
| Асуудал 2: Авлагын талаар | Тэргүүлэх ач холбогдол №1 |
|---------------------------|---------------------------|

**"Стандарт дүгнэлт аудит" ХХК-ийн ажиглалт**

Харилцагч байгууллагуудтай үүссэн өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан эсэхийг шалгах явцад "Амин Нетворкс" ХХК-тай "Хүнсний бүтээгдэхүүний захиалгын програм хангамж" хийлгэхээр гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрт 875.0 мянган төгрөг төлсөн боловч програмаа хийлгээгүй,үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалтыг зөрчсөн.

**Эрсдэлүүд**

Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг зөрчсөн байх

**Оршин байх-** Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байхбатламж мэдэгдэл зөрчигдөх

**"Стандарт дүгнэлт аудит" ХХК-ийн зөвлөмж**

Амин Нетворкс" ХХК-аас авах авлагыг тооцоо нийлж, баталгаажуулан, гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж, асуудлыг эцэслэн шийдвэрлэх;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг засаж, өгсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

**Асуудал 3: Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримт бичгийн талаар****Тэргүүлэх ач холбогдол №1****"Стандарт дүгнэлт аудит" ХХК-ийн ажиглалт**

"НБББББ" нь шинээр мөрдөж байгаа стандарт болон хууль эрхийн зарим актын өөрчлөлтийг тусгаагүй байна. Үүнд: Үндсэн хөрөнгөнд байгуулах элэгдэлийн хувь хэмжээг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөлт хийгээгүй, бараа материалыг зарлага болгох бодлого, аргачлал, цэвэр хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэх бодлого зэргийг холбогдох стандартад нийцүүлэн шинэчилээгүй.

**Эрсдэлүүд**

**Үнэн зөв байдал-** Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байхбатламж мэдэгдэл зөрчигдөх

**"Стандарт дүгнэлт аудит" ХХК-ийн зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийгөөрийн байгууллагын онцлог, шинээр мөрдөж байгаа стандарт, эрх зүйн орчинтой нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулан баталгаажуулах.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг засаж, өгсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ****ХЯНАСАН:**

Дэд дарга:

С.Энхбаатар

Аудитын менежер:

А.Цогбаяр

Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн захирал

В.Даваасүрэн

**БЭЛТГЭСЭН:**

Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн аудитор

Д.Майцэцэг

**-АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2016-12-31-нээр дуусвар болсон санхүүгийн тайлан

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ                                                                        | 2015-12-31            | 2016-12-31            |
|---------------|---------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| <b>1</b>      | <b>ХӨРӨНГӨ</b>                                                                  |                       |                       |
| <b>1.1</b>    | <b>Эргэлтийн хөрөнгө</b>                                                        |                       |                       |
| 1.1.1         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө                                                 | 26,440,243.03         | 16,046,730.07         |
| 1.1.2         | Дансны авлага                                                                   | 15,719,980.00         | 5,023,800.00          |
| 1.1.3         | Татвар, НДШ – ийн авлага                                                        |                       | 35,000.00             |
| 1.1.4         | Бусад авлага                                                                    | 3,245,599.00          | 4,666,890.00          |
| 1.1.5         | Бусад санхүүгийн хөрөнгө                                                        |                       |                       |
| 1.1.6         | Бараа материал                                                                  | 78,387,062.03         | 59,809,802.51         |
| 1.1.7         | Урьдчилж төлсөн зардал/тооцоо                                                   | 15,200,000.00         | 37,475,000.00         |
| 1.1.8         | Бусад эргэлтийн хөрөнгө                                                         |                       |                       |
| 1.1.9         | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) |                       |                       |
| 1.1.10        | Дуусаагүй барилга                                                               |                       |                       |
| <b>1.1.11</b> | <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>                                                  | <b>138,992,884.06</b> | <b>123,057,222.58</b> |
| <b>1.2</b>    | <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>                                                    |                       |                       |
| 1.2.1         | Үндсэн хөрөнгө                                                                  | 127,918,992.14        | 183,410,871.57        |
| 1.2.2         | Биет бус хөрөнгө                                                                | 377,287.67            | 270,000.00            |
| 1.2.3         | Биологийн хөрөнгө                                                               |                       |                       |
| 1.2.4         | Урт хугацаат хөрөнгө оруулалт                                                   |                       |                       |
| 1.2.5         | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө                                                   |                       |                       |
| 1.2.6         | Хойшлогдсон татварын хөрөнгө                                                    |                       |                       |
| 1.2.7         | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө                               |                       |                       |
| 1.2.8         | Бусад эргэлтийн бус хөрөнгө                                                     | 8,000,000.00          | 8,000,000.00          |
| 1.2.9         | Дуусаагүй барилга                                                               |                       |                       |
| <b>1.2.10</b> | <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>                                              | <b>136,296,279.81</b> | <b>191,680,871.57</b> |
| <b>1.3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                                       | <b>275,289,163.87</b> | <b>314,738,094.15</b> |
| <b>2</b>      | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>                                                  |                       |                       |
| <b>2.1</b>    | <b>Өр төлбөр</b>                                                                |                       |                       |
| <b>2.1.1</b>  | <b>Богино хугацаат өр төлбөр</b>                                                |                       |                       |
| 2.1.1.1       | Дансны өглөг                                                                    | 74,635,314.00         | 41,348,549.00         |
| 2.1.1.2       | Цалингийн өглөг                                                                 |                       |                       |
| 2.1.1.3       | Татварын өр                                                                     | 1,007,752.85          | 144,571.58            |
| 2.1.1.4       | НДШ-ийн өглөг                                                                   |                       |                       |
| 2.1.1.5       | Банкны богино хугацаат зээл                                                     |                       |                       |
| 2.1.1.6       | Хүүний өглөг                                                                    |                       |                       |
| 2.1.1.7       | Ногдол ашгийн өглөг                                                             |                       |                       |
| 2.1.1.8       | Урьдчилж орсон орлого                                                           | 48,750,000.00         |                       |
| 2.1.1.9       | Нөөц /өр төлбөр/                                                                |                       |                       |

## "ХҮНС ХАНГАМЖ ТӨВ" ОНӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

|          |                                                                                                         |                |                |
|----------|---------------------------------------------------------------------------------------------------------|----------------|----------------|
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр                                                                         |                |                |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр |                |                |
| 2.1.1.12 | Бусад өглөг                                                                                             |                |                |
| 2.1.1.13 | <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>                                                                 | 124,393,066.85 | 41,493,120.58  |
| 2.1.2    | <b>Урт хугацаат өр төлбөр</b>                                                                           |                |                |
| 2.1.2.1  | Урт хугацаат зээл                                                                                       |                |                |
| 2.1.2.2  | Нөөц /өр төлбөр/                                                                                        |                |                |
| 2.1.2.3  | Хойшлогдсон татварын өр                                                                                 |                |                |
| 2.1.2.4  | Бусад урт хугацаат өр төлбөр                                                                            |                |                |
| 2.1.2.6  | <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>                                                                    | -              | -              |
| 2.2      | <b>Өр төлбөрийн нийт дүн</b>                                                                            | 124,393,066.85 | 41,493,120.58  |
| 2.3      | <b>Эздийн өмч</b>                                                                                       |                |                |
| 2.3.1    | - төрийн                                                                                                | 1,000,000.00   | 1,000,000.00   |
| 2.3.2    | - хувийн                                                                                                |                |                |
| 2.3.3    | - хувьцаат                                                                                              |                |                |
| 2.3.4    | Халаасны хувьцаа                                                                                        |                |                |
| 2.3.5    | Нэмж төлөгдсөн капитал                                                                                  |                |                |
| 2.3.6    | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл                                                                     |                |                |
| 2.3.7    | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц                                                                       |                |                |
| 2.3.8    | Эздийн өмчийн бусад хэсэг                                                                               | 45,921,028.30  | 166,629,728.30 |
| 2.3.9    | Хуримтлагдсан ашиг                                                                                      |                |                |
| 2.3.10   | Тайлант үеийн ашиг                                                                                      | 103,975,068.72 | 105,615,245.27 |
|          | Өмнөх үеийн                                                                                             |                |                |
| 2.3.11   | <b>Эздийн өмчийн дүн</b>                                                                                | 150,896,097.02 | 273,244,973.57 |
| 2.4      | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>                                                                   | 275,289,163.87 | 314,738,094.15 |

## АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016-12-31-нээр дуусвар болсон санхүүгийн тайлан

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ                                                         | 2015-12-31       | 2016-12-31       |
|---------------|------------------------------------------------------------------|------------------|------------------|
| 1             | <b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>                               | 3,919,980,120.38 | 4,098,070,836.03 |
| 2             | Борлуулалтын өртөг                                               | 3,620,887,697.00 | 3,792,389,815.52 |
| 3             | <b>Нийт ашиг ( алдагдал)</b>                                     | 299,092,423.38   | 305,681,020.51   |
| 4             | Түрээсийн орлого                                                 |                  |                  |
| 5             | Хүүний орлого                                                    |                  | 56,732.10        |
| 6             | Ногдол ашгийн орлого                                             |                  |                  |
| 7             | Эрхийн шимтгэлийн орлого                                         |                  |                  |
| 8             | Бусад орлого                                                     | 1,600,000.00     | 3,992,929.00     |
| 9             | Борлуулалт, маркетингийн зардал                                  | 189,411,118.77   | 223,798,339.96   |
| 10            | Ерөнхий ба удирдлагын зардал                                     | 88,405,988.32    | 73,969,154.37    |
| 11            | Санхүүгийн зардал                                                |                  |                  |
| 12            | Бусад зардал                                                     | 9,249,252.00     | 6,498,292.00     |
| 13            | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)                       |                  |                  |
| 14            | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                       |                  |                  |
| 15            | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                     |                  |                  |
| 16            | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)                  |                  |                  |
| 17            | Бусад ашиг ( алдагдал)                                           |                  |                  |
| 18            | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>                     | 13,626,064.29    | 5,464,895.28     |
| 19            | Орлогын татварын зардал                                          | 2,686,573.63     | 1,636,818.73     |
| 20            | <b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>                           | 10,939,490.66    | 3,828,076.55     |
| 21            | <b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b> |                  |                  |
| 22            | <b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>                       | 10,939,490.66    | 3,828,076.55     |
| 23            | <b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>                                  |                  |                  |
|               | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү                      |                  |                  |
| 24            | <b>Орлогын нийт дүн</b>                                          | 10,939,490.66    | 3,828,076.55     |
| 25            | <b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>               |                  |                  |

"ХҮНС ХАНГАМЖ ТӨВ" ОНӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016-12-31-нээр дуусвар болсон санхүүгийн тайлан

| №  | ҮЗҮҮЛЭЛТ                                              | Өмч          | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг |
|----|-------------------------------------------------------|--------------|------------------|------------------------|-------------------------------------|---------------------------|--------------------|
| 1  | 2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл                   | 1,000,000.00 | -                | -                      | 45,921,028.30                       | 103,975,068.72            | 150,896,097.2      |
| 2  | НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга |              |                  |                        |                                     |                           |                    |
| 3  | Залруулсан үлдэгдэл                                   | 1,000,000.00 | -                | -                      | 45,921,028.30                       | 103,975,068.72            | 150,896,097.2      |
| 4  | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)                   |              |                  |                        |                                     |                           |                    |
| 5  | Бусад дэлгэрэнгүй орлого                              |              |                  |                        |                                     |                           |                    |
| 9  | 2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл                   | 1,000,000.00 | -                | -                      | 45,921,028.30                       | 103,975,068.72            | 150,896,097.2      |
| 10 | НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга |              |                  |                        |                                     |                           |                    |
| 11 | Залруулсан үлдэгдэл                                   | 1,000,000.00 | -                | -                      | 45,921,028.30                       | 103,975,068.72            | 150,896,097.2      |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)                   |              |                  |                        |                                     | 3,828,076.55              | 3,828,076.55       |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого                              |              |                  |                        |                                     |                           |                    |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт                                 |              |                  |                        | 120,708,700.00                      |                           | 120,708,700.00     |
| 15 | Зарласан ногдол ашиг                                  |              |                  |                        |                                     | (2,187,900.00)            | (2,187,900.00)     |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн             |              |                  |                        |                                     |                           |                    |
| 17 | 2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл                   | 1,000,000.00 | -                | -                      | 166,629,728.30                      | 105,615,245.27            | 273,244,973.53     |